



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 1/432

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгаа, арчилгааны зардалд 5,049,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 5,049,000 (Таван сая дөчин есөн мянга) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл хөтөлбөр арга хэмжээний 5.9-өөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батсайхан), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Анхбаяр) нарт зөвшөөрсүгэй.

3. Нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламжийн усалгаа арчилгааг тогтмол хийж арчлан ургуулахыг аймгийн Хот тохижуулах газрын дарга (Ц.Билгүүн)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Энхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



МАМАРСАНАА

8400001 1286

Zah A/432 Och

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 04-ний өдрийн
А/432 дугаар захирамжийн хавсралт



ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Авто машины нэр	Шатахууны үнэ	Өдөрт хэрэглэх шатахуун (л)	Сард (л)	90 хоног	Нийт үнэ
1	Усны машин (Dong Feng 0153ХОЕ)	3300	17	510	1530	5,049,000

-oOo-